



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/07

Сайншанд сум

Албан хаагчдын сургалт, зөвлөгөөнийг
зохион байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/1716 дугаартай "Байгууллагын дотоод журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, мөн журмын 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус хэлтсийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу улсын бүртгэгч нарыг мэргэшүүлэх, салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээллээр хангах, төрийн албан хаагчдын ёс зүйн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор "Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын сургалт, зөвлөгөөн"-ийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсугай.

2. Сургалт, зөвлөгөөний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, сургалт зөвлөгөөнд оролцох албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар, хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, зөвлөгөөнийг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (С.Эрдэнэхишиг)-д үүрэг болгосугай.

4. Сургалт, зөвлөгөөнд шаардагдах 1500.000 (Нэг сая таван зуун мянга) төгрөгийг хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (У.Буянбат)-д зөвшөөрсүгэй.


5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны ахлах мэргэжилтэн (С.Эрдэнэхишиг)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЭНХ-ЭРДЭНЭ

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын
2026 оны 03 дугаар сарын 20 өдрийн
03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

1.1. Албан хаагчдыг нэгдсэн удирдлагаар хангаж, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиг үүргийн хүрээнд иргэдэд хүргэх үйлчилгээг сайжруулж, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, цаашдын бодлого зорилтоо тодорхойлоход оршино.

Хоёр. Хамрах хүрээ, хугацаа:

2.1. Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчдын дунд 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдана.

2.2. Сургалт, зөвлөгөөн "Саруул төв"-ийн 3 дугаар давхарын хурлын танхимд болно.

Гурав. Сургалт, зөвлөгөөний чиглэл

3.1. Сургалт, зөвлөгөөн дараах чиглэлээр зохион байгуулагдана. Үүнд:

3.1.1. Сумын улсын бүртгэгч нар төрөлжсөн архивын баримт хүлээлгэн өгөх.

3.1.2. УБЕГ-ын удирдах ажилтны зөвлөгөөн-2026 арга хэмжээний хүрээнд гарсан бодлого шийдвэрийн талаар нийт албан хаагчдад нэгдсэн ойлголт өгөх.

3.1.3. Албан хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хувь хүний ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт өгөх.

3.1.4. Хиймэл оюун ухааны чиглэлээр албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх, мэдээллээр хангах зорилгоор сургалт зохион байгуулах.

3.1.5. Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон албан хаагчдыг удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж нэгдсэн ойлголтод хүрэх, өдөр тутмын үйл ажиллагааг чанаржуулах, төрийн үйлчилгээг хүндрэлгүй үзүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулах.

3.1.6. Үнэт цаасны зарцуулалт болон анхаарах асуудлын талаар мэдээлэл хийх.

3.1.7. Албан хаагчдын хамтын сангийн зарцуулалтын талаар мэдээлэл хийх.

3.1.8. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ" хэлэлцүүлэг зохион байгуулах.

3.1.9. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хэлтсийн албан хаагчдын

2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах.

Дөрөв. Хүрэх үр дүн

4.1. Хэлтсийн албан хаагчид мэргэжил арга зүйгээр хангагдаж, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үзүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, хэрэгжүүлэх арга хэмжээ болон цаашдын бодлого зорилтоо тодорхойлсон байна.

Тав. Үр дүнг тайлагнах

5.1. Албан хаагчдын сургалт, зөвлөгөөний үр дүнг Захиргааны ахлах мэргэжилтэн С.Эрдэнэхишиг 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр илтгэх хуудсаар тайлагнана.

---- оОо ----

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын
2026 оны 02 дугаар сарын 18 өдрийн
01/07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

Д/д	Албан тушаал	Овог, нэр
Захиргаа, аж ахуй		
1	Хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Сумъяагийн Энх-Эрдэнэ
2	Захиргааны ахлах мэргэжилтэн	Сандагдоржийн Эрдэнэхишиг
3	Хяналтын улсын байцаагч	Эрдэнэбаатарын Уранбилэг
4	Ерөнхий нягтлан бодогч	Ухнаагийн Буянбат
5	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Нэргүйн Цэндмаа
6	Мэдээлэл, технологийн ажилтан	Пүрэв-Осорын Азжаргал
7	Архивч	Должинсүрэнгийн Баярсайхан
8	Жолооч	Төмөртоогоогийн Чинцогт
Иргэний бүртгэлийн тасаг		
9	Иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч	Баттөмөрийн Баттуяа
10	Улсын бүртгэгч	Эрдэнэтогтохын Ариунтуяа
11	Айраг сумын улсын бүртгэгч	Батмөнхийн Уранчимэг
12	Даланжаргалан сумын улсын бүртгэгч	Лимбийн Нямхүү
13	Дэлгэрэх сумын улсын бүртгэгч	Жанчивын Өлзийжаргал
14	Иххэт сумын улсын бүртгэгч	Дүгэрийн Мөнхцэцэг
15	Зам-Үүд сумын улсын бүртгэгч	Содовжамцын Шүрэндулам
16	Замын-Үүд сумын улсын бүртгэгч	Дамдинсүрэнгийн Цэцэгсүрэн
17	Өргөн сумын улсын бүртгэгч	Дамбачойдорын Сарантуяа
18	Сайншанд сумын улсын бүртгэгч	Өлзийчулууугийн Сонинбаяр
19	Сайхандулаан сумын улсын бүртгэгч	Михлайн Наранцацрал
20	Улаанбадрах сумын улсын бүртгэгч	Баатаржавын Нарангуа
21	Хатанбулаг сумын улсын бүртгэгч	Хүрээтийн Хишигжаргал
22	Хөвсгөл сумын улсын бүртгэгч	Төмөртоогоогийн Энхтуяа
Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг		
23	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч	Гунаасүрэнгийн Батсайхан
24	Улсын бүртгэгч	Бат-Эрдэнийн Номин-Эрдэнэ
25	Улсын бүртгэгч	Бибишийн Сийлэгмаа

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын
2026 оны 03 дугаар сарын 18 өдрийн
18/07 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН 2026 ОНЫ
СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨНИЙ ХӨТӨЛБӨР

2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр

Сайншанд хот

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Анхаарах асуудал
2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр				
1	Сумын бүртгэгч нар төрөлжсөн архивын баримт материалыг хүлээлгэн өгөх	14:00-18:00	Д.Баярсайхан	Батлагдсан загварын дагуу баримт хүлээлгэн өгөх
2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр				
1	Сургалт, зөвлөгөөний бүртгэл хийх	08:00-08:10	Захиргааны ахлах мэргэжилтэн С.Эрдэнэхишиг	Албан хаагчдыг бүртгэж хурлын зааланд оруулах
2	Хөтлөгч зөвлөгөөнийг хөтөлбөрийг танилцуулна.	08:10-08:15	Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг	Сургалтын хөтөлбөр болон анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч чиглүүлэх
3	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ сургалт зөвлөгөөнийг нээж үг хэлнэ.	08:15-08:30	Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ	
4	Сэдэв: "Өөрөөс эхлэх манлайлал"	08:30-09:40	Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Б.Сэмжидтуяа	
5	Сэдэв: Улсын бүртгэлийн байгууллагын бодлого, чиглэлийн талаар нэгдсэн ойлголт өгөх	09:40-10:30	Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ	
6	Цайны завсарлага	10:30-10:50		Цаг баримтлах
7	Сэдэв: "Хиймэл оюуны оновчтой хэрэглээ"	10:50-12:00	Эмпасофт технологийн сургуулийн дэд захирал Н.Энхсайхан	
8	Үдийн завсарлага	12:00-13:00		Цаг баримтлах
10	Сэдэв: Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын бодлого, чиглэлийн	13:00-14:00	Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ	

	талаар нэгдсэн ойлголт өгөх			
11	Сэдэв: "Иргэний улсын бүртгэлийн баталгаажуулалт анхаарах асуудал"	14:00-14:30	Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч	
12	Сэдэв: "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал"	14:30-15:00	ЭХЭБ-ийн улсын ахлах бүртгэгч Г.Батсайхан	
13	Сэдэв: "Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал"			
14	Сэдэв: "Зөрчлөөс урьдчилан сэргийлэх" талаар мэдээлэл өгөх	15:00-15:30	Хяналтын улсын байцаагч Э.Уранбилэг	
15	Цайны завсарлага	15:30-15:50		Цаг баримтлах
16	Сэдэв: "Үнэт цаасны зарцуулалт болон анхаарах асуудал"	15:50-16:20	Ерөнхий нягтлан бодогч	
17	Сэдэв: "Хамтын сангийн зарцуулалт"	16:20-16:50	Архив, бичиг хэргийн эрхлэгч	
18	Сэдэв: "Үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ" хэлэлцүүлэг	16:50-17:50	Сумын бүртгэгч нар	
19	Төрийн жинхэнэ албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах	17:50-18:10	Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ	
20	Сургалт, зөвлөгөөнийг хааж үг хэлнэ.	18:10-18:30	Хэлтсийн дарга С.Энх-Эрдэнэ	